



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/98

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Сумын төвийн нутаг дэвсгэрт их хэмжээний гадаргын ус гарч айл өрх, хашаа байшин, 00, хогын цэг шар усны үерт автаж эрсдэлтэй нөхцөл үүссэн, ундны усны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх зөрчигдөх хэмжээнд хүрч байгаа тул айл өрх, хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэх, далан барих, суваг шуудуу татах ажлын зардалд дэмжлэг болгон Рэнчинлхүмбэ суманд 5.000.000 (Таван сая) төгрөг олгосугай.

2. Дээрх зардлын 5.000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Шуурхай штабын дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН